# ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.БАТБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах” | | | | | | |
| 1. | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг CEPS-д илгээж байна. | Эхний хагас жилд:<br>-Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн байна. | Улсын хилээр түр хугацаанд нэвтэрч байгаа гадаад, дотоодын тээврийн хэрэгслийн улсын хилээр нэвтрэх бүртгэлийн хүсэлтийг гаалийн байгууллагад илгээх гар утсанд зориулсан програм хангамжийн хөгжүүлэлт хийлгэх шийдлийг судалж, СМТТ УТҮГ-т саналаа 2024.09.24-ний өдрийн 02-1/3895 дугаартай албан бичгээр хүргүүлж, хамтран ажилласан.<br>Дээрх асуудлыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т шийдвэрлэх боломжгүй тул И-Монгол Академи УТҮГ-ын систем нэгтгэлийн газрын төслийн менежер С.Цэвээнсүрэн, системийн шинжээч А.Эрдэнэцэцэг, цахим засаглалын хэлтсийн процесс аналист Г. Будням, шинжээч Е-Г.Оюунгэрэл нартай уулзалт зохион байгуулж, Е-Монголиа апп-д улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч, гаалийн байгууллагатай холбогдох модул гаргуулахаар тохиролцсон.<br>Үүний дагуу тээвэрлэгчээс хил нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн хүсэлт илгээх асуудлыг гар утасны програм хангамжид суурилсан хэлбэрээр цахим төлбөрийн баримтын ebarimt системээс шийдвэрлэх технологийн гарц, шийдлийг судалж, И Монгол Академи УТҮГ-т захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.И-Монгол Академи УТҮГ-ын шинжээч нартай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулж, захиалагчийн шаардлага, процессын зураглалыг тайлбарын хамт хүргүүлсэн.<br>2.Апп-р тээврийн хэрэгслийг бүртгүүлэхэд: | 01.02<br>12.10 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Иргэн регистрийн дугаараар хүсэлтээ илгээхэд 5 минут<br>-Хур системээс мэдээлэл харуулахад 1 мин буюу нийт 6 минут зарцуулдаг болно.<br>3.Дээрх програмыг улсын төсвөөс зардал гаргахгүйгээр төлбөргүй хийлгэж 2024.12.15-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлнэ. | | |
| 2. | Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх зорилгоор боомтуудад ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажил төлөвлөгдсөн<br>. | Эхний хагас жилд: ГХБ-д ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хяналтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байна. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд боомт руу орох, гарах хаалга болон боомт доторх замын эгнээнүүд дээр RFID-г суурилуулж, боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулахаар ажиллаж байна.<br>Хилийн боомт:<br>**-Гашуунсухайт** боомтын нүүрсний терминалын экспортын хэсгийн 4, импортын хэсгийн 3 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан 2023.02.17-ны өдрөөс эхлэн өдөртөө хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Тус боомтын шинэчлэл, бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор өнөөдрийн байдлаар нүүрсний гарах хэсэгт хяналтын бүсрүү орох 2, хяналт шалгалтын саравч доор суурилуулсан 4 ухаалаг гарцыг тогтмол ашиглаж байна. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрсний терминалын 35, зорчигчийн терминалын 20, зэсийн баяжмалын хэсэгт 4 буюу нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан. Хилээр гарах талын рентген, дээж авагчийн ухаалга гарцын ажил нь хүлээгдэж байна.<br>**-Шивээхүрэн** боомтын нүүрсний терминалын гарах хэсэгт 7, орох чиглэлийн 3 хэсэгт суурилуулсан RFID-ээр 2023.10.25-ны өдрөөс эхлэн тус боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийг бүртгэж байна.<br>**-Замын-Үүд** боомтын зорчигч тээврийн терминалд 54, ачааны терминалын 39 байршилд ухаалаг гарцын системын тоног төхөөрөмжийг 2023.01.08-ны өдөр хийж суурилуулж, дуусгасан. Ачааны терминалын үйл ажиллагааг 2023.11.27-ны өдрөөс эхлүүлж, 14 байршилд суурилуулсан RFID-ээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж байна. | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **-Ханги**: ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажиллаж, тус боомтод 11 байршилд суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг шалган, 2024.12.10-ны өдрөөс тээврийн хэрэгслийг RFID-ээр бүртгэх ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.<br>Гүний гаалийн хяналтын бүс:<br>ГХБ-д оруулж, гаргаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэх RFID-г суурилуулж, бодит цагийн горимд СМТТ УТҮГ-ын smartgate.ecustoms.mn системд холбуулах даалгаврыг 2024.02.28-ны өдрийн 02-1/762 дугаартай албан бичгээр ГХБ эзэмшигч нарт хүргүүлсэн. Дээрх ажилтай холбогдуулан RFID болон системд тавигдах шаардлагыг gaali.mn -ын “Гарын авлага, заавар” хэсэгт байршуулж, мэдээлэл өгч, албан даалгаврын хүрээнд УБГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулж байгаа ГХБ эрхлэгч нартай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Өнөөдрийн байдлаар:<br>-АБТЭМА, Монголтранс, Туушин ГХБ-д суурилуулсан;<br>-Бусад ГХБ-д RFID-г суурилуулахад 55-70 орчим сая төгрөгийн зардал гарахаар тооцоолол гарсан тул судалж байна гэсэн хариу ирүүлсэн. RFID-г Цагаанхад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 27 ГХБ-д суурилуулсан, үйл ажиллагаа явуулахгүй байгаа 14 ГХБ-д суурилуулаагүй буюу тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ГХБ-ийн 93% нь RFID суурилуулсан.<br>Шивээхүрэн боомтоор нүүрс экспортлогч 6 компани уурхай дахь талбайд RFID-г бүрэн суурилуулсан. СМТТ УТҮГ-тай холбогдон програмын хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Гашуунсухайт боомтын нүүрсний терминалын 7 эгнээ замд тус бүрт нь RFID-г түр суурилуулан хилээр гарч байгаа нүүрс ачсан тээврийн хэрэгслүүдийг бүртгэсэн. Гашуунсухайт боомтод 2024.11.30-ны өдрийн байдлаар нүүрс, зорчигч, зэсийн баяжмалын хэсэгт нийт 59 эгнээ, замд RFID-г суурилуулахаас 57 гарцад суурилуулсан төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниас хүлээж авсан.<br>2.УБГГ, ГСГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулдаг 30 ГХБ-д RFID-г суурилуулсан.<br>3.Алтанбулаг боомтод RFID суурилуулах ажлыг RIBS төслөөр хэрэгжүүлэхээр тендер, сонгон шалгаруулалт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | явагдаж байгаа тул энэ ажил гаалийн байгууллагаас шалтгаалахгүй.<br>4.Баянхошуу боомтын бүтээн байгуулалт эхлээгүй тул RFID суурилуулах ажил хийгдээгүй нь гаалийн байгууллагаас шалтгаалахгүй. | | |
| 3. | Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | Хэрэгжилт гүйцэтгэлээр | -Хилийн хяналтын байгууллагууд хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийг тус тусдаа бүртгэдэг учраас мэдээлэл зөрөх, алдаа гарах зэрэг сөрөг үр дагавар гарсан. | Эхний хагас жилд:<br>-Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна. | Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас:<br>1.тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах;<br>2.хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. Үүний үр дүнд улсын хилээр орох болон гарах талд хил нэвтэрсэн авто тээврийн хэрэгслийн дугаараар ХХЕГ-аас сервисээр мэдээлэл татах боломжийг бүрдүүлсэн. Тус мэдээлэлд жолооч, зорчигчийн овог, нэр, регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, төрсөн он сар өдрөөр Хил хамгаалах ерөнхий газрын баталгаажуулсан мэдээллийг хүлээн авч гаалийн хяналт шалгалтад ашиглах, эрсдэл тооцох боломжтой болгосон. Мөн цаашид төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээр хил нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг Хил хамгаалах байгууллагын баталгаажуулсан мэдээллийг авахаар ажиллаж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулан | 01.02<br>12.10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулан, сервисын мэдээллээ дахин шинэчилж хүргүүлсэн.<br>2.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх ХУН төслийн хүрээнд программ хийлгэж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох туршилтыг 2024 оны 11 дүгээр сард Замын-Үүд боомтод хийж, нэвтрүүлсэн. | | |
| 4. | Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн хяналтыг сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаар тушаалаар батлагдсан Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд хяналт сайжруулах зохицуулалт нэмж оруулах шаардлага үүссэн.<br>- Гаалийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 138.3, 139 дүгээр зүйлийн 139.1.7-д 2023.11.10-ны өдрийн хуулиар ТБД-ийн зөвшөөрлийг дуудлага худалдааны үндсэн дээр олгох | Эхний хагас жилд:<br>-Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг сайжруулсан байна.<br>-Татваргүй барааны дэлгүүрийн дуудлага худалдааны журмын төсөл боловсруулсан байна. | 1.МУ-ын ДШЗХТ-ын 2023.12.25-ны өдрийн 02-р тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаартай тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх тушаалаар ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан Зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигчдийн худалдан авалтын давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх нөхцөл байдал үүсгэхгүй болгох зорилготой зохицуулалтыг тусгасан.<br>2.“Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулж Захиргааны ерөнхий хуулийн 62-т заасны дагуу customs.gov.mn-д 2024.06.10-ны өдөр байршуулж олон нийтээс санал авсан. Төслийг танилцуулж, санал авах зорилгоор СЯ, ГХЯ, ИНЕГ, NUBA ХХК, гаалийн газар, хороодын дарга нарт 2024.06.07-ны өдрийн 02/2319- 02/2323 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. ГЕГ-ын ЗББНДБ-д 2024.06.07-ны өдрийн 225 дугаартай дотоод зурвасаар хүргүүлж, CERP-д байршуулсан. ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу СЯ-аас ирүүлэх саналыг хүлээж байна.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулж, 5 удаа албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласны үр дүнд зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигч худалдан авах давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх оролдлогыг багасгасан. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зохицуулалт оруулсан. | | 2.Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах журам"-ын төслийг боловсруулж, ГЕГ-ын МЗХ-д танилцуулахад бэлтгэсэн. ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу СЯ-аас ирүүлэх саналыг хүлээж байна. | | |
| 5 | Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | Эхний хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна. | Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ЗУГ-т хугацаанд нь, ХХ-т сар бүр тогтмол хүргүүлсэн:<br>Засгийн газрын тогтоол:<br>-Цагааннуур" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай 2022 оны 412;<br>Засгийн газрын тэмдэглэл:<br>-Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2022 оын 362 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх 2023.09.06-ны өдрийн 36-р тэмдэглэлийн 3.3 дахь заалт<br>-Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах арга хэмжээний талаар 2023.10.04-ний өдрийн 40 дүгээр тэмдэглэлийн 2 дахь заалт<br>-Алтанбулагийн чөлөөт бүсэд импортоор худалдаалагдаж байгаа архи, согтууруулах ундааны худалдан авалттай холбоотой хязгаарлалт хийсэн асуудлыг Ажлын хэсэг байгуулан судлан шийдвэрлэх тухай 2023.09.20-ны өдрийн 38 дугаар тэмдэглэлийн XII.7.15 дахь заалт. | 01.02<br>12.10 | 100 |
| 6 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Удирдлагаас өгсөн цаг үеийн шинжтэй үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлж ажилласан. | Эхний хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. | 1.ГЕГ-ын даргын 2022 оны А/350, А/351 дугаар тушаалтай холбогдуулан "Итирнатитур" ХХК болон нэр бүхий 11 компанийн нэхэмжлэлтэй, ГЕГ-ын даргад холбогдох захиргааны хэргийн тухай Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2023.12.25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг гаалийн байгууллага 2024.01.19-ний өдөр хүлээн авсан.<br>Дээрх тогтоолыг хүлээн авч, 2024.01.19-ний өдрийн 02-1/274 дугаартай албан бичгээр шүүхийн тогтоолыг хэрэгжүүлж ажиллах тухай чиглэлийг Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын даргад хүргүүлсэнтэй холбогдуулан Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс гаргасан гомдолд хариу тайлбар болон холбогдох бичиг баримтыг бүрдүүлж Хяналт хэрэгжүүлэх газрын хянан | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгагч Ц.Идэрбаттай 2024.02.16-ны өдрийн 09:00 цагт уулзан тайлбар өгч, холбогдох бичиг баримтуудыг хүлээлгэн өгсөн.<br>СЯ-ны ТБГ-ын дарга Тэлмүүнтэй ГЕГ-ын ХБГ-ын дарга Б.Даваасүрэн, ГУАБ Б.Болормаа, ХХ-ийн дарга Ч.Тамираа нарын хамт 2024.04.01-ний өдрийн 16:00 цагт уулзаж, чөлөөт бусийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, тодорхой давтамжтайгаар согтууруулах ундааг зорчигч нар худалдан авах зохицуулалт, оруулж, хяналт шалгалтыг сайжруулах ажиллах чиглэл авч, санал солилцсон.<br>3.Улаанбаатар хотноо 2024.05.29,30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Их Түмэн Санаачилгын Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооны 6 дугаар худалдаан болон Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдаанд оролцсон.<br>4.Монгол Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2023.12.25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тогтоолыг буруугаар тайлбарлаж, Алтанбулаг чөлөөт бүсээс худалдаж авсан согтууруулах ундааг гаалийн нутаг дэвсгэрт гаалийн болон бусад татваргүйгээр оруулж байна гэсэн зар тарааж, эмх замбараагүй байдал үүсгэсэн. Иймд дээрх СЭГГ-т ААН-ийн төлөөлөлтэй 2024.02.08-ны өдөр уулзалт зохион байгуулж, ХБГ-ын дарга Б.Даваасүрэн, ХХ-ийн дарга Ч.Тамираа нартай хамт томилолтоор ажилласан. | | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Ажлын цагаар үр дүнтэй ажилласан. | -Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг | 2024 онд ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж:<br>-томилолтоор ажиллах 3;<br>-уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 14;<br>-ээлжийн амралтын 1;<br>-чөлөөний 2;<br>-бусад 10;<br>-хурлын өрөөний 4 буюу нийт 34 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.<br>2024 онд 4532 илүү цаг ажилласан бүртгэл CERP-д байна. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | CERP-д тухай бүр оруулан, илгээнэ. | | | |
| Зорилт 4:"Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" | | | | | | | |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | -АБ чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдан борлуулдаг нэр бүхий 11 ААН-ийн гомдлыг УДШ-ийн ЗХТШ-ийн хуралдаж, 2023.12.25-ны өдөр хэлэлцсэн. | -Ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах зааврын төсөлд саналаа өгнө.<br>-Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, ХЗДХЯ-д хүргүүлнэ. | -ГЕГ-ын даргын 2024 оны А/532 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн хяналт, шалгалтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар"-ыг батлуулан хяналт тавьж ажиллаж байна. Энэхүү зааврaар автозамын хилийн боомтоор нэвтрүүлэх, гаалийн хяналтын бүсэд оруулах, гаргах тээврийн хэрэгслийн бүртгэлийг цахимжуулж, хяналтыг сайжруулах зорилгоор RFID (Radio Frequency Identification Data) радио давтамжит долгион бүхий тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж, мэдээллийг гаалийн байгууллагад илгээх, гаалийн байгууллагаас илгээсэн хариу мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд боловсруулалт хийж жолоочид мэдээлэл хүргүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулна.<br>-МУ-ын ДШЗХТ-ын 2023.12.25-ны өдрийн 02-р тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2019 оны А/282 дугаартай тушаалаар батлагдсан "Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Дээрх тушаалаар ГЕГ-ын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан Зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигчдийн худалдан авалтын давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх нөхцөл байдал үүсгэхгүй болгох зорилготой зохицуулалтыг тусгасан.<br>Хүрсэн үр дүн:<br>1.Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ГЕГ-ын даргын 2024 оны А/338 дугаар тушаалыг батлуулж, 5 удаа албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласны үр дүнд зорчигчийн журмын 2.3.1-д заасан барааг чөлөөт бүсэд зорчигч худалдан авах давтамжийг бууруулж, татвараас зайлсхийх оролдлогыг багасгасан.<br>2.ГЕГ-ын даргын 2024 оны А/532 дугаар тушаалын хавсралтаар "Гаалийн хяналт, шалгалтад ухаалаг гарцын тоног төхөөрөмж ашиглах заавар"-ыг батлуулан хяналт тавьж ажиллаж байна. | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

**Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын хэсгийн хуралд оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ХБЗ-аас зохион байгуулах хуралд оролцох. | Хилийн Нарансэвстэй-Мазушань боомтыг нээн ажиллуулах чиглэлээр судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн 2024.01.19-ний өдрийн 15:00 цагт Хилийн Боомтын захиргааны байрны 431 тоот өрөөнд зохион байгуулагдсан хуралд оролцсон. | 01.19 01.19 | 100 |
| 2 | Томилолтоор ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Замын-Үүд боомтод томилолтоор ажиллах | Замын-Үүд боомтын ачааны терминалын импортын талд суурилуулсан ухаалаг гарцын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах, сургалтад хамрагдах, ШУТ-өөс хяналт тавих боломжийг хангахаар 2024.01.22-2024.01.25-ны өдрийн хооронд ШУТ-ийн ГУБ нарын хамт томилолтоор ажилласан. | 01.22 01.25 | 100 |
| 3 | Ажлын хэсгийн хуралд оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | ЭЗХЯ-д зохион байгуулагдах хуралд оролцох | “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хилийн удирдлагын нэгдсэн /ХУН/ системийг хөгжүүлэх ажлын хэсгийн 2024.01.26-ны өдрийн 15:00-17:00 цагт ЭЗХЯ-д зохион байгуулагдсан хурал оролцсон. | 01.26 01.26 | 100 |
| 4 | Хуралд оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | БСҮХ-оос зохион байгуулсан хуралд оролцох. | БСҮХ-оос 2024.04.12-ны өдрийн 13:00 цагт зохион байгуулсан химийн хорт бодис ачиж, буулгах зориулалттай гаалийн хяналтын бүс тогтоохтой холбоотой хуралд ХБГ-ын дарга Б.Даваасүрэнгийн хамт оролцсон. | 04.12 04.12 | 100 |
| 5 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Төслийн багтай хамтарч ажиллах | "Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдаа төсөл"MON-55044-ийн багаас 2024.05.06-10, 2024.06.04,05-ны өдрүүдэд БСҮХ-ны байранд зохион байгуулагдах СЯ, АХБ-ны ажилтануудтай хамтарсан уулзалтад оролцсон. | 05.06 06.05 | 100 |
| 6 | УБГГ-т ажиллаж судалгаа хийх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | УБГГ-т ажиллаж судалгаа хийх | УБГГ-ын хяналт тавьж ажилладаг Туушин ГХБ-д ТЕГ-ын байцаагч Отгонбаяр , ГТСМТГ УҮГ-ын мэргэжилтэн, МТГ-ын ГУАБ Мөнхзултай нарын хамт онцгой албан татварын тэмдэгттэй | 09.16 09.16 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбоотой хөгжүүлэлтийн талаар судалгаа хийхээр 2024.09.16-ны өдөр ажилласан. | | |
| 7 | Хуралд оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЭЗХАБ-ийн бүтээн байгуулалт, гүний гарцын асуудлаар зохион байгуулагдах хуралд оролцох | Замын-Үүд Эрээний ЭЗХАБ-ийн бүтээн байгуулалт, гүний гарцын асуудлаар 2024.10.04 -ний өдрийн 09:00 цагаас Сонголт дизайн ХХК-ийн байранд зохион байгуулагдах хуралдаанд удирдлагаас өгсөн үүргийн дагуу ХБГ-ын ГУАБ Ц.Цэвээндарийн хамт оролцсон. | 10.04<br>10.04 | 100 |
| 8 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан уулзалтад оролцох | Алтанбулаг чөлөөт бүсэд шилэн кабель холбох ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, ГЕГ-ын ХБГ, МТГ, ШХТ-ийн ГУБ нар уулзалт зохион байгуулж, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд Мобиком компаниас үзүүлж буй үйлчилгээний мэдээллийг хүргүүлсэн. | 10.08<br>10.08 | 100 |
| 9 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | АТГ-ээс зохион байгуулах хэлэлцүүлэгт оролцох | АТГ, СЯ, ГЕГ, ТЕГ, СМТТ УТҮГ-аас СЯ-д хамтран 2024.10.08-ны өдөр зохион байгуулсан "Санхүү, татвар, гаалийн байгууллагын цахимжилт, түүний үр нөлөө ба иргэн, хуулийн этгээдтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх арга зам" хэлэлцүүлэгт оролцож, санал солилцсон. | 10.08<br>10.08 | 100 |
| 10 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж буй 100 ажилтанд 2024.02.01-ний өдрүүдэд гаалийн бүрдүүлэлт, гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн горимтой холбоотой сэдвээр хичээл заасан. | 02.01<br>02.01 | 100 |
| 11 | Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах | Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч 100 сонсогч нарт 2024.02.16-ны өдөр гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн горимтой холбоотой хичээл заасан. | 02.16<br>02.16 | 100 |
| 12 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Онцгой албан татвартай барааг мэдүүлэхтэй | УБГГ-ын хурлын танхимд 60 зуучлагч байгууллагын 100 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт Татварын ерөнхий газар, | 07.03<br>07.03 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нарт хичээл заах | | | холбогдуулан програмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн ГБМ нарт талаар хичээл заах. | ГТСМТТ УҮГ-ын ажилтануудтай хамтран онцгой албан татвартай барааг мэдүүлэхтэй холбогдуулан татварын байгууллагын Цахим татварын систем, Цахим төлбөрийн баримтын систем, Татварын удирдлагын систем, гаалийн байгууллагын CEPS-д оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар сургалт зохион байгуулсан. | | |
| 13 | Согтууруулах ундаа импортлогч нарт мэдээлэл өгөх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Онцгой албан татвартай барааг мэдүүлэхтэй холбогдуулан програмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар согтууруулах ундаа импортлогч нарт хичээл заах. | ТЕГ-ын хурлын танхимд согтууруулах ундаа импортлогч ААН-ийн төлөөлөлд Татварын ерөнхий газар, ГТСМТТ УҮГ-ын ажилтануудтай хамтран онцгой албан татвартай барааг мэдүүлэхтэй холбогдуулан татварын байгууллагын Цахим татварын систем, Цахим төлбөрийн баримтын систем, Татварын удирдлагын систем, гаалийн байгууллагын CEPS-д оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаар сургалт зохион байгуулсан. | 07.04<br>07.04 | 100 |
| 14 | Хамтарсан уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ЗТХЯ-аас 2024.07.05-ны өдрийн 03/2960 дугаартай албан бичгээр ирүүлсэн зарын дагуу уулзалтад оролцох. | ЗТХЯ-аас 2024.07.18-ны өдрийн 10:00 цагт зохион байгуулсан Гашуунсухайт боомтын шилжүүлэн ачих терминалаар дамжуулан Оюутолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай автозамаар нүүрсний тээвэрлэлт хийх асуудлаар ХХЕГ, ХБЗ, Оюу толгой ХХК-ийн төлөөлөл оролцсон хамтарсан уулзалтад ХБГ-ын Б.Даваасүрэн даргын хамт оролцсон. хойшилсон | 07.18<br>07.18 | 100 |
| 15 | Уулзалт зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | СЯ-ны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Б.Болормаатай уулзаж, зөвлөгөө авах | Гаалийн байгууллагад цахимаар хүсэлт ирүүлсэн ААН-ийн санхүүгийн чадавхийг тооцох үзүүлэлтийг lisence.mn-д Сангийн сайдын 2023 оны 206 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх аргачлал"-тай уялдуулж, өөрчлөлт оруулах асуудлаар СЯ-ны Нягтлан бодох бүртгэлийн газрын дарга Б.Болормаатай ГУАБ Б.Болормаагийн хамт 2024.07.18-ны өдрийн 15:00 цагт уулзаж, зөвлөгөө авсан. | 07.18<br>07.18 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | Уулзалтад оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Шивээхүрэн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүнийг AGV тээвэрлэлтээр гаргахтай холбоотой цахим уулзалтад оролцох | Шивээхүрэн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүнийг AGV тээвэрлэлтээр гаргахтай холбоотойгоор чингэлэг тус бүрт ачигдсан нүүрсний жинг уурхай дээрх гүний гаалийн хяналтын бүсээс тодорхойлох асуудлаар ШХГГ, МАК ХХК-ийн төлөөлөлтэй хамтарсан уулзалтыг 2024.07.25-ны өдрийн 15:00 цагт цахимаар зохион байгуулсан. | 07.25<br>07.25 | 100 |
| 17 | УБГГ-т ажиллаж, судалгаа хийх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | УБГГ-ын хяналт тавьж ажилладаг Туушин ГХБ-д ажиллаж, судалгаа хийх | УБГГ-ын хяналт тавьж ажилладаг Туушин ГХБ-д ТЕГ-ын байцаагч Отгонбаяр , ГТСМТГ УҮГ-ын мэргэжилтэн, МТГ-ын ГУАБ Мөнхзултай нарын хамт онцгой албан татварын тэмдэгттэй холбоотой хөгжүүлэлтийн талаар судалгаа хийхээр 2024.09.16-ны өдөр ажилласан. | 09.16<br>09.16 | 100 |
| 18 | Хуралд оролцож, мэдээлэл өгөх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдах зөвлөлийн хуралдаанд оролцох. | Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдах зөвлөлийн 2024.11.29-ний өдрийн 14:00 цагийн хуралдаанд оролцож, тус зөвлөлийн дарга, 6 гишүүнд ГУБ Д.Ням-Осорын хамт оролцож, нар улс хоорондын шуудан илгээмжид тавих гаалийн хяналт, бүрдүүлэлт, UPOST, гаалийн зөрчил, гаалийн хяналтын бүсийн бүрдүүлэлтийн талаарх мэдээлэл өгч, PPT танилцуулсан. | 11.29<br>11.29 | 100 |

**Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | | |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | |
| 1 | Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах | Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна. | ГЕГ-ын даргын 2024.04.22-ны өдрийн А/209 дугаар тушаалаар БНХАУ-ын Худалдааны яамнаас Хөх хотод 2024.04.23-2024.05.02-ны өдрийн хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа сэдвээр зохион байгуулсан, сургалтад оролцсон. | 04.24<br>04.25 | 100 |
| 2 | TABLEAU DESKTOP сургалтад хамрагдах. | Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна. | ГЕГ-т 2024 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан TABLEAU DESKTOP сургалтад хамрагдаж, өгөгдөл, мэдээлэл холбох, өгөгдлийн эх үүсвэрийг засварлах, хадгалах, Tableau Interface-ийг ашиглан үр ашиг үзүүлэх хүчирхэг дүрслэлүүд бүтээх, арифметик үйлдлүүд | 10.23<br>10.24 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | болон функц ашиглан тооцоолол хийх, хүснэгтэн тооцооллууд хийх, дашбоард, тайлангаа бусадтай хуваалцах талаар суралцсан. | | |
| 3 | Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах. | Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна. | Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна. | 01.02<br>06.05 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН
УЛСЫН БАЙЦААГЧ /М.БАТБИЛЭГ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.БАТБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

## 1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | 50 | 3 | 53 | |
| 2. | Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | 56 | 6 | 62 | |
| 3. | Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | 50 | 6 | 56 | |
| 4 | Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүсийн хяналтыг сайжруулах | 55 | 6 | 61 | |
| 5 | Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 56 | 6 | 62 | |
| 6 | Үүрэг даалгаврын биелэлт | 57 | 7 | 64 | |
| 7 | Ажлын цаг ашиглалт | 55 | 5 | 60 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Зорилт 4:"Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" | | | | | |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 60 | 5 | 65 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1 | Ажлын хэсгийн хуралд оролцох | 60 | 10 | 70 | |
| 2 | Томилолтоор ажиллах | 60 | 10 | 70 | |
| 3 | Ажлын хэсгийн хуралд оролцох | 60 | 10 | 70 | |
| 4 | Хуралд оролцох | 60 | 10 | 70 | |
| 5 | Уулзалтад оролцох | 60 | 10 | 70 | |
| 6 | УБГГ-т ажиллаж судалгаа хийх | 60 | 10 | 70 | |
| 7 | Хуралд оролцох | 60 | 10 | 70 | |
| 8 | Уулзалтад оролцох | 60 | 10 | 70 | |
| 9 | Уулзалт хэлэлцүүлэгт оролцох | 60 | 10 | 70 | |
| 10 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 11 | Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 12 | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах | 60 | 10 | 70 | |
| 13 | Согтууруулах ундаа импортлогч нарт мэдээлэл өгөх | 60 | 10 | 70 | |
| 14 | Хамтарсан уулзалтад оролцох | 60 | 10 | 70 | |
| 15 | Уулзалт зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 16 | Уулзалтад оролцох | 60 | 10 | 70 | |
| 17 | УБГГ-т ажиллаж, судалгаа хийх | 60 | 10 | 70 | |
| 18 | Хуралд оролцож, мэдээлэл өгөх | 60 | 10 | 70 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний | Нийт | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, |
|---|---|---|---|---|
| | | | | |

| | | биелэлтийн хувь | (15 хүртэл оноогоор) | дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | ГЕГ-ын даргын 2024.04.22-ны өдрийн А/209 дугаар тушаалаар БНХАУ-ын Худалдааны яамнаас Хөх хотод 2024.04.23-2024.05.02-ны өдрийн хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа сэдвээр зохион байгуулсан, сургалтад оролцсон. | 100 | 15 | |
| 2 | Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах. | 80 | 12 | |
| **Дундаж оноо** | | | 13.5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ<br>(0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо** | | **6.6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 8 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)* | 67 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13.5 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.6 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 95.1 |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............................ (Б.Даваасүрэн)

......................(огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ............................ (М.Батбилэг)

......................(огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

XII.20. 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2024.12.20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***

Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

.............................. (огноо)